



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	3-4
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	10
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	11
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	11
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	15
ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	16
ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА	17
4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд:	17
4.2. Экспорт:	20
4.3. Импорт:	24
ТАВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	27
5.1. Мөнгөний нийлүүлэлт:	27
5.2. Гадаад валютын албан нөөц:	29
5.3. Төлбөрийн тэнцэл:	30
ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	32
6.1. Хүн ам, ажил эрхлэлт:	32
6.2. Ажилгүйдэл:	32

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 5.6 хувиар өсжээ. Эдийн засгийн өсөлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2.0 хувьтай гарч байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 14.4 их наяд төгрөг болж, 5.6 хувьд хүрсэн байна. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр оруулсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 14,198.8 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 12,911.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,287.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 14,198.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3,617.4 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 101.3 хувьтай байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 2024 оны эхний хагас жилийн улирлын гүйцэтгэлээр 12,911.3 тэрбум төгрөгт хүрч, 78.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 3,887.5 тэрбум төгрөгөөр буюу 42.9 хувиар нэмэгдсэн байна.

Засгийн газрын өр: Засгийн газрын өрийн хэмжээ 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 30,247.1 тэрбум төгрөг (нэрлэсэн дүн) байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 862.7 тэрбум төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 13,266.4 сая ам.доллар, экспортын худалдаа 7,888.4 сая ам.доллар, импортын худалдаа 5,377.9 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 2,510.5 сая ам.долларын ашигтай гарсан. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад 2024 оны эхний хагас жилийн байдлаар экспорт 334.8 сая ам.доллар буюу 4.4 хувиар, импорт 1,104.5 сая ам.доллар буюу 25.8 хувиар тус тус өссөн байна. Нийт экспортын орлогын 59.9 хувийг нүүрс, 18.4 хувийг зэсийн баяжмал, 4.4 хувийг алт, 3.7 хувийг төмрийн хүдэр, 2.1 хувийг боловсруулаагүй нефть, 1.7 хувийг жоншны баяжмал тус тус эзэлж байна. 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр импортын худалдаа 5,377.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.8 хувь буюу 1,104.5 сая ам.доллаар өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 41,467.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 10,019.1 тэрбум төгрөг буюу 31.9 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 3,308.2 тэрбум төгрөг буюу 44.3 хувиар, төгрөгийн хадгаламж 5,252.5 тэрбум төгрөг буюу 36.5 хувиар, гадаад валютын харилцах 1,835.8 тэрбум төгрөг буюу 51.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 5.1 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар буурсан байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 804.6 сая ам.долларын алдагдалтай байсан хэдий ч хөрөнгийн тэнцэл 18.5 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 602.0 сая ам.долларын тус тус ашигтай гарсан.

Гадаад валютын нөөц өслөө. Нийт албан нөөцийн хэмжээ 2024 оны 6 сард 4,838.8 сая ам.доллар болж, 2023 оны жилийн эцсээс 82.7 сая ам.доллар буюу 1.7 хувиар буурсан хэдий ч өнгөрсөн оны мөн үеэс 1,021.0 сая ам.доллар буюу 26.7 хувиар өссөн байна.

Гадаад валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 оны 06 дугаар сард 3,381.0 төгрөг болж, өмнөх оноос 57.0 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 466.0 төгрөг болж, өмнөх оноос 14.0 төгрөгөөр мөн чангарсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл 1,235.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 90.1 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.7 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурлаа.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 1,957.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 256.8 тэрбум төгрөг буюу 11.6 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 2.9 нэгж хувиар буурчээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2024 оны эхний хагас жилийн байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 14.4 их наяд төгрөг болж, 5.6 хувийн өсөлт үзүүлэв.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улиралд өсөж 1.9 хувьд хүрч байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5.6 хувийн өсөлттэй гарлаа.

График 1-д 2016-аас 2024 оны эхний хагас жилийн байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ болон олон улсын зах зээлийн үнэ тус тус нэмэгдсэнээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа эдийн засгийн бодит өсөлт сайжрах төлөвтэй байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 37.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.8 хувь буюу 6.4 их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 14.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувь буюу 0.8 их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр оруулсан байна.


Уул уурхайн салбар 2024 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудын оролцоо /хувь/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн гүйцэтгэл						
	2018	2019	2020	2021	2022	2023	2024
ДНБ	6.9	7.6	-9.0	6.3	2.0	6.7	5.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.5	0.3	1.7	-0.8	1.8	-1.7	-3.9
Уул уурхай, олборлолт	0.4	1.7	-4.6	2.6	-4.0	3.9	1.8
Боловсруулах үйлдвэрлэл	1.0	0.1	-0.4	0.7	-0.2	0.1	0.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	0.1	0.1	0.3	0.2	0.1	0.2
Барилга	-0.1	0.4	0.0	-0.9	-0.2	0.1	0.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.5	1.6	-1.6	0.5	1.4	0.8	0.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.2	0.3	-1.3	0.3	-0.6	1.9	1.0
Мэдээлэл, холбоо	0.2	0.3	0.1	0.5	0.4	0.4	0.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.5	1.7	-1.3	0.1	1.5	0.7	2.1
Бүтээгдэхүүний цэвэр татвар	2.5	1.1	-1.6	3.0	1.7	0.4	2.3


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт, оны үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2.0 хувьтай гарч байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5.6 хувь болж өссөн байна.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2024 оны эхний хагас жилийн байдлаар 38.0 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 24.5 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 14.1 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018-II	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II	2024-II	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	15,085.8	17,652.6	17,134.2	19,563.9	22,746.9	30,540.4	38,022.4	24.5
Эцсийн хэрэглээ	11,082.1	12,771.5	14,169.5	13,382.1	16,419.0	18,750.1	26,057.0	39.0
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	9,108.2	10,372.3	11,424.8	10,832.8	13,475.6	14,695.1	18,988.6	29.2
Төрийн байгууллагын хэрэглээ	1,973.9	2,399.2	2,744.6	2,549.3	2,943.3	4,055.0	7,068.5	74.3
Хөрөнгийн нийт хуримтлал	4,941.0	5,275.7	4,511.5	6,552.8	9,487.7	8,062.2	9,985.2	23.9
Үндсэн хөрөнгийн хуримтлал	3,621.4	4,636.4	3,932.0	4,851.6	5,659.1	7,222.7	7,755.7	7.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	1,319.6	639.4	579.5	1,701.2	3,828.6	839.5	2,229.5	165.6
Цэвэр экспорт	-937.2	-394.6	-1,546.8	-371.0	-3,159.8	3,728.1	1,980.2	-46.9
Бараа, үйлчилгээний экспорт	9,220.6	11,213.5	8,082.0	11,325.0	12,422.0	25,699.8	27,317.9	6.3
Бараа, үйлчилгээний импорт	10,157.9	11,608.1	9,628.8	11,696.0	15,581.7	21,971.7	25,337.8	15.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018-II	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II	2024-II	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	11,873.9	12,793.5	11,831.6	12,562.5	12,542.3	13,328.5	14,094.7	5.7
Эцсийн хэрэглээ	10,124.6	10,718.1	11,471.2	10,446.9	11,211.7	12,182.7	15,042.3	23.5
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	8,236.2	8,619.5	9,166.3	8,320.6	8,943.1	9,527.9	11,141.5	16.9
Төрийн байгууллагын хэрэглээ	1,888.4	2,098.5	2,304.9	2,126.3	2,268.7	2,654.8	3,900.8	46.9
Хөрөнгийн нийт хуримтлал	4,198.6	4,422.4	3,308.5	4,786.6	6,581.5	4,717.6	5,548.8	17.6
Үндсэн хөрөнгийн хуримтлал	3,192.2	3,838.2	3,043.3	3,426.3	3,896.0	4,166.2	4,193.5	0.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	1,006.5	584.3	265.2	1,360.4	2,685.6	551.4	1,355.3	145.8
Цэвэр экспорт	-2,449.3	-2,347.0	-2,948.1	-2,671.1	-5,251.0	-3,571.7	-6,496.4	81.9
Бараа, үйлчилгээний экспорт	6,603.1	6,994.1	5,120.4	5,836.3	5,005.0	9,657.4	9,460.2	-2.0
Бараа, үйлчилгээний импорт	9,052.4	9,341.1	8,068.5	8,507.3	10,256.0	13,229.1	15,956.5	20.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад эдийн засгийн бодит өсөлт 5.7 хувиар /эцсийн ашиглалтын аргаар тооцсон/ өсөхөд өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4. ДНБ-ий бодит өсөлт, салбараар, хувиар

Бүрэлдэхүүн	Эхний хагас жилийн гүйцэтгэл						
	2018	2019	2020	2021	2022	2023	2024
ДНБ	7.1	7.7	-7.5	6.2	-0.2	6.3	5.7
Эцсийн хэрэглээ	12.5	5.9	7.0	-8.9	7.3	8.7	23.5
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	15.4	4.7	6.3	-9.2	7.5	6.5	16.9
Төрийн байгууллагын хэрэглээ	1.4	11.1	9.8	-7.7	6.7	17.0	46.9
Хөрөнгийн нийт хуримтлал	59.9	5.3	-25.2	44.7	37.5	-28.3	17.6
Үндсэн хөрөнгийн хуримтлал	41.3	20.2	-20.7	12.6	13.7	6.9	0.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	174.6	-41.9	-54.6	412.9	97.4	-79.5	145.8
Цэвэр экспорт	355.1	-4.2	25.6	-9.4	96.6	-32.0	81.9
Бараа, үйлчилгээний экспорт	16.8	5.9	-26.8	14.0	-14.2	93.0	-2.0
Бараа, үйлчилгээний импорт	46.2	3.2	-13.6	5.4	20.6	29.0	20.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг ажилтанд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг ажилтанд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцоолоход 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар буюу 703.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Салбараар нь авч үзвэл, аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмж 38.7 мянган төгрөг (1.0 хувь)-өөр нэмэгдсэн боловч хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 2,098.8,7 мянган төгрөг (35 хувь)-өөр, үйлчилгээний салбарын бүтээмж 422.3 мянган төгрөг (8.0 хувь)-өөр, уул уурхайн салбарын бүтээмж 316.0 мянган төгрөг (2.5 хувь)-өөр тус тус буурчээ.

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

Бүрэлдэхүүн	Эхний хагас жилийн гүйцэтгэл							Өөрчлөлт, 2024/2023	
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	5,359.1	6,332.3	5,684.9	6,156.4	6,244.8	6,639.3	5,935.8	- 703.5	-10.6
Хөдөө аж ахуй	4,862.5	5,454.2	6,792.3	6,004.2	6,780.4	6,000.9	3,902.2	-2,098.7	-35.0
Уул уурхай, олборлолт	14,645.2	15,465.8	12,062.6	12,626.7	9,230.7	12,702.4	12,386.4	-316.0	-2.5
Аж үйлдвэр, барилга	4,057.5	4,710.3	4,011.5	3,644.0	3,333.4	3,843.4	3,882.1	38.7	1.0
Үйлчилгээ	3,766.4	4,622.2	3,859.4	4,706.4	4,906.1	5,286.6	4,864.3	-422.3	-8.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 14,198.8 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 12,911.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,287.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3,617.4 тэрбум төгрөг буюу 34.2 хувиар, төсвийн нийт зарлага 3,877.5 тэрбум төгрөг буюу 42.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	Өөрчлөлт(+/-)	
		2024.06/2023.06				
		1	2		3	(3-2)
	2024.06	2023.06	2024.06	(3:1)	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	14,018.6	10,581.3	14,198.8	101.3	3,617.4	34.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	16,363.3	9,033.8	12,911.3	78.9	3,877.5	42.9
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,344.8	1,547.5	1,287.5	-54.9	-260.0	-16.8
ДНБ, оны үнээр		30,979.6	37,419.7		6,440.1	
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		5.0	3.4		-1.6	

Эх сурвалж: : Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 101.3 хувийн, нийт зарлага 78.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, нийт тэнцэл 1,287.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 3.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурсан нь ДНБ 6,440.1 тэрбум төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөнтэй холбоотой байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 14,198.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 34.2 хувиар буюу 3,617.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 1.3 хувь буюу 180.2 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Тэнцвэржүүлсэн нийт орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл улсын төсөв 2.7 хувь буюу 261.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол орон нутгийн төсөв 3.4 хувь буюу 112.5 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 2.3 хувь буюу 67.8 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 7.2 хувь буюу 73.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 34.8 хувь буюу 2,520.8 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 66.1 хувь буюу 1,271.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сан 48.9 хувь буюу 929.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 24.5 хувь буюу 187.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, төсвийн шатлалаар

/тэрбум төгрөгөөр/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	10,114.3	10,504.2	3,308.9	3,196.3	2,897.6	2,829.7	1,027.5	953.8
Ирээдүй өв сан	401.7	527.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	217.8	220.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,494.8	9,755.8	3,308.9	3,196.3	2,897.6	2,829.7	1,027.5	953.8
Татварын орлого	8,254.3	8,622.4	2,595.4	2,563.4	2,090.8	2,023.0	1,027.5	953.8
Татварын бус орлого	1,240.5	1,133.4	713.5	632.9	806.7	806.7	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 93.6 хувийг татварын орлого, 6.4 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлого /хувиар/




2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр Тогтворжуулалтын санд 217.8 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 401.7 тэрбум төгрөг хуваарилахаар төлөвлөснөөс Тогтворжуулалтын санд 220.7 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 527.7 тэрбум төгрөг хуваарилсан байна. Ирээдүйн өв сангийн хөрөнгө 131.4 хувийн биелэлттэй буюу 126.0 тэрбум төгрөг, Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 101.3 хувиар буюу 2.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Нэгдсэн төсвийн татварын орлого 13,291.0 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 101.7 хувийн биелэлттэй байгаа ба өмнөх оны мөн үеэс 35.1 хувь буюу 3,449.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлого: Татварын орлогын 32.1 хувийг орлогын албан татвар, 15.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 20.9 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 3.9 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 19.3 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 6. Татварын орлого /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам


2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн татварын орлого төлөвлөснөөс 1.7 хувь буюу 216.5 тэрбум төгрөгөөр давж биелэсэн байна. Үүнд, орлогын албан татвар 4.3 хувь (174.9 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 5.5 хувь (12.5 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 6.5 хувь (156.1 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр татварын орлого 35.1 хувь буюу 3,449.8 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 67.2 хувь (1,714.9 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 17.3 хувь (309.7 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 21.1 хувь (41.8 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 27.3 хувь (594.6 тэрбум төгрөг), онцгой албан татвар 37.8 хувь (141.4 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 22.6 хувь (2.3 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 18.5 хувь (127.1 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 25.3 хувь (517.9 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр татварын бус орлого 907.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 167.6 тэрбум төгрөгөөр буюу 22.6 хувиар өссөн бол төлөвлөснөөс 36.3 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар дутуу төвлөрчээ.

Татварын бус орлогын 79.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 20.7 хувийг тусламжийн орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 42.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 17.9 хувийг газрын тосны орлого, 14.0 хувийг торгуулийн орлого, 13.5 хувийг бусад орлого, 10.1 хувийг хүүгийн орлого, 1.5 хувийг навигацыйн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна.

График 7. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад гадаад хандив тусламжийн орлого 38.9 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 3.6 тэрбум төгрөгийн дутуу биелэлтэй байна.

Нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 54.1 тэрбум, торгуулийн орлого 23.7 тэрбум, хүүгийн орлого 23.1 тэрбум, бусад орлого 2.8 тэрбум, түрээсийн орлого 0.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол навигацыйн орлого 70.9 тэрбум, газрын тосны орлого 17.8 тэрбум, хувьцааны ногдол ашгийн орлого 9.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 16,363.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 78.9 хувийг зарлагадаж, 3,452.0 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 3,877.5 тэрбум төгрөг буюу 42.9 хувиар өсөж, 12,911.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨО-ны мөн үеийн /2023.06/	Эхний хагас жилийн байдлаар			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,033.8	16,363.3	12,911.3	78.9	-3,452.0
НИЙТ ЗАРЛАГА	9,000.5	16,195.0	12,672.2	78.2	-3,522.7
УРСГАЛ ЗАРДАЛ	7,556.6	12,134.0	10,376.2	85.5	-1,757.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,044.6	5,311.0	4,244.8	79.9	-1,066.2
ХҮҮ	513.8	701.0	595.1	84.9	-105.9
ТАТААС	266.5	509.9	366.7	71.9	-143.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,731.8	5,612.0	5,169.6	92.1	-442.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,443.9	4,061.0	2,296.0	56.5	-1,765.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	33.3	168.3	239.1	142.0	70.7

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн онтой харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 37.3 хувиар буюу 2,819.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 80.4 хувь буюу 10,376.2 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 49.8 хувийг урсгал шилжүүлэг, 40.9 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 5.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.5 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардал 2,200.2 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 437.9 тэрбум төгрөг, татаас 100.2 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 81.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 852.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 34.2 хувь буюу 3,617.4 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 42.9 хувь буюу 3,877.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 8.7 нэгж хувиар их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 260.0 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “Засгийн газрын өр”-ийг тодорхойлсон, тухайлбал 4.1.8.а-д өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, 4.1.8.б-д хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг” гэж тодорхойлсон. Засгийн газрын дотоод өр гэж өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, Засгийн газрын гадаад өр гэж Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг тус тус ойлгоно.

Хүснэгт 9. Засгийн газрын өр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн гүйцэтгэл								
	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023*	2024*
I.Засгийн газрын дотоод өр (өрийн хэрэгслээр)	3,744.9	4,596.6	2,112.5	1,485.8	1,338.1	1,046.1	531.8	651.6	141.6
Үнэт цаас	3,145.	4,596.6	2,112.5	1,485.8	1,338.1	1,046.1	531.8	651.6	141.6
II.Засгийн газрын гадаад өрI (өрийн хэрэгслээр)	9,632.9	13,606.7	16,810.7	19,289.2	22,697.8	24,331.2	26,559.	29,366.8	29,346.5
Үнэт цаас	4,241.5	6,486.7	7,142.2	7,707.5	8,186.6	7,976.2	8,994.9	9,070.6	8,716.3
Зээл	5,391.4	7,119.9	9,668.5	11,581.7	14,511.1	16,354.9	17,564.1	20,296.2	20,630.2
III.Засгийн газрын бусад өр	3,234.6	2,583.8	2,160.1	1,910.3	1,904.4	1,717.8	1,432.5	1,091.4	759.0
Засгийн газрын өрийн баталгаа	2,915.6	1,777.9	1,560.1	1,104.3	1,071.4	955.3	940.7	744.1	254.5
Барих-шилжүүлэх концесс	319.	805.9	600.0	806.0	833.0	762.5	491.8	342.8	-
Орон нутгийн зээллэг	-	-	-	-	-	-	-	4.5	504.5
Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл (I+II+III)	16,612.4	20,787.1	21,083.3	22,685.3	25,940.3	27,095.1	28,523.3	31,109.8	30,247.1
Засгийн газрын өрийн үлдэгдэл (Өнөөгийн үнэ цэнээр)	-	-	-	-	-	-	-	27,033.6	26,157.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам*

Засгийн газрын өрийн хэмжээ 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 30,247.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 862.7 тэрбум төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Үүнд; Засгийн газрын дотоод үнэт цаас 510.0 тэрбум төгрөгөөр буюу 78.3 хувиар, Засгийн газрын гадаад өр 20.3 тэрбум төгрөгөөр буюу 0.1 хувиар, Засгийн газрын бусад өр 332.4 тэрбум төгрөг буюу 30.5 хувиар, үүн дотроо Засгийн газрын өрийн баталгаа 489.6 тэрбум төгрөгөөр буюу 65.8 хувиар, барих-шилжүүлэх концесс 342.8 тэрбум төгрөгөөр буюу 100.0 хувиар тус тус буурсантай холбоотой байна.


Засгийн газрын өрийн хэмжээг ковидын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 7,561.8 тэрбум төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн байгаа ба үүнд Засгийн газрын гадаад өр 10,057.3 тэрбум төгрөгөөр буюу 52.1 хувиар өссөн (гадаад үнэт цаас 1,008.8 тэрбум төгрөг буюу 13.1 хувь, гадаад зээл 9,048.5 тэрбум төгрөг буюу 78.1 хувь) нь нөлөөлжээ.

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2024 оны эхний хагас жилийн байдлаар 148 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 13,266.4 сая ам.долларт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 6,433.6 сая ам.доллар буюу 94.1 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 1,439.4 сая ам.доллар буюу 12.1 хувиар тус тус өссөн байна.

2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан. Тухайлбал, гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний 6 сард 1,045.4 сая ам.долларын ашигтай байсан бол 2024 оны мөн үеийн гүйцэтгэлээр 2,510.5 сая ам.долларт хүрч 2.4 дахин нэмэгдсэн байна.

График 8. Гадаад худалдааны үзүүлэлт, 2018.06-2024.06 оноор /сая ам.доллар/




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 13,266.4 сая ам.доллар, экспортын худалдаа 7,888.4 сая ам.доллар, импортын худалдаа 5,377.9 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 2,510.5 сая ам.долларын ашигтай тус тус гарсан.

График 9. Экспорт, импортын өөрчлөлт /хувь/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2019-2024 оны эхний хагас жилийн байдлаар экспорт дунджаар 40.4 хувиар, импорт 33.5 хувиар тус тус өссөн нь гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Ялангуяа, 2021-2024 оны эхний улирлын байдлаар экспорт дунджаар 57.5 хувиар, импорт 45.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад 2024 оны эхний хагас жилийн байдлаар экспорт 334.8 сая ам.доллар буюу 4.4 хувиар, импорт 1,104.5 сая ам.доллар буюу 25.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, 2020-2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар					/сая ам.доллар/ Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлт	5,288.2	7,334.1	9,257.1	11,827.0	13,266.4	1,439.4	12.2
Экспорт	2,828.1	4,072.7	5,309.1	7,553.6	7,888.4	334.8	4.4
Импорт	2,460.1	3,261.5	3,948.0	4,273.4	5,377.9	1,104.5	25.8
Тэнцэл	368.1	811.2	1,361.0	3,280.1	2,510.5	-769.6	-23.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 769.6 сая ам.доллаароор буурч, 2,510.5 сая ам.долларын ашигтай гарсан. Импортыг экспортоор нөхөх коэффициент 2023 оны эхний хагас жилийн байдлаар 176.7 хувь байсан бол 2024 оны мөн үед 146.7 хувь болжээ.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: 2024 оны эхний хагас жилийн байдлаар валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 98.6 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 95.9 хувийг тус тус эзэлж байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 2,507.8 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 781.7 сая ам.доллар буюу 23.8 хувиар буурсан байна.

Валютын төлбөртэй экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 280.6 сая ам.доллар буюу 3.7 хувиар, валютын төлбөртэй импортын орлого 1,032.9 сая ам.доллар буюу 25.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл


Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар			/сая ам.доллаароор/ Харьцуулсан хувь (2024/2023)
	2022	2023	2024	Хувь
НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	9,257.1	11,827.0	13,266.4	12.2
А.Экспорт	5,309.1	7,553.6	7,888.4	4.4
А1.Валютын төлбөртэй бараа	5,281.8	7,492.0	7,772.6	3.7
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	99.5	99.2	98.5	-0.7
В.Импорт	3,948.0	4,273.4	5,377.9	25.8
В1.Валютын төлбөртэй бараа	3,855.1	4,173.6	5,156.9	23.6
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	97.6	97.7	95.9	-1.8
С. Тэнцэл (А-В):	1,361.0	3,280.1	2,510.5	-23.5
Д. Импортыг экспортоор нөхөх коэффициент ((А/В)*100)	134.5	176.7	146.7	-17.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2024.06)-аар тооцон үзэв.

2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

График 10. Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн өөрчлөлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнууд (ОХУ, БНХАУ) Монгол Улсын гадаад худалдаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр хөрш орнууд нийлээд Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 82.2 хувь, экспортын 93.2 хувь, импортын 65.9 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс:

- БНХАУ-тай хийсэн худалдаа нь Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 71.5 хувь (9.5 тэрбум ам.доллар), экспортын 92.5 хувь (7.3 тэрбум ам.доллар), нийт импортын 40.6 хувь (2.2 тэрбум ам.доллар)-ийг эзэлжээ.
- ОХУ-ын хувьд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 10.7 хувь (1.4 тэрбум ам.доллар), экспортын 0.7 хувь (55.2 сая ам.доллар), нийт импортын 25.3 хувь (1.4 тэрбум ам.дол)-ийг эзэлж байна.
- БНХАУ-тай хийсэн худалдаа 5,118.2 сая ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа 1,308.1 сая ам.долларын алдагдалтай байна.

Бусад улс оронтой хийсэн худалдаа гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 17.8 хувь, экспортын 6.8 хувь, импортын 34.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Улс орон	Төрөл	Эзлэх хувь /2024.06/	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт (+/-)	
			2020	2021	2022	2023	2024	2024.06/2023.06	
			Дүн		Хувь				
БНХАУ	Нийт эргэлт	71.5	2,963.7	5,004.3	5,646.5	8,663.7	9,483.3	819.6	9.5
	Экспорт	92.5	2,113.3	3,705.1	4,274.8	6,998.9	7,300.7	301.8	4.3
	Импорт	40.6	850.4	1,299.3	1,371.7	1,664.8	2,182.6	517.8	31.1
	Тэнцэл		1,262.9	2,405.8	2,903.1	5,334.1	5,118.2	-216.0	-4.0
ОХУ	Нийт эргэлт	10.7	699.3	897.5	1,248.2	1,185.1	1,418.5	233.4	19.7
	Экспорт	0.7	24.4	50.0	35.4	48.5	55.2	6.7	13.8
	Импорт	25.3	675.0	847.5	1,212.8	1,136.6	1,363.3	226.7	19.9
	Тэнцэл	-	-650.6	-797.5	-1177.4	-1088.1	-1308.1	-220.0	20.2
Бусад	Нийт эргэлт	17.8	1,625.2	1,432.4	2,362.5	1,978.3	2,364.6	386.3	19.5
	Экспорт	6.8	690.4	317.6	999.0	506.2	532.5	26.3	5.2
	Импорт	34.1	934.8	1,114.7	1,363.5	1,472.0	1,832.1	360.0	24.5
	Тэнцэл	-	-244.3	-797.1	-364.6	-965.8	-1299.6	-333.8	34.6


4.2. Экспорт:

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр экспортын худалдаа 7,888.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 334.8 сая ам.доллар буюу 4.4 хувиар өссөн байна. 2019 он (Цар тахлын өмнөх үе)-той харьцуулахад 3,949.3 сая ам.доллар буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 11. Экспорт, бүлгээр

2019 онтой харьцуулсан өөрчлөлт, хувиар



2019 оны эхний хагас жилтэй харьцуулахад 2020 оны мөн үед буурсан хэдий 2021-2024 оны мөн хугацаанд эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт аль аль нь өссөн байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар эрдэс бүтээгдэхүүний экспорт 7,016.2 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 431.8 сая ам.доллар буюу 6.6 хувиар өссөн байна. 2024 оны эхний хагас жилд эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 88.9 хувь байна.

Хүснэгт 13. Экспорт, бүлгээр /2019.06-2024.06/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт экспорт	2,828.1	4,072.7	5,309.1	7,553.6	7,888.4	334.9	4.4
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	2,020.6	3,387.7	4,436.9	6,584.5	7,016.2	431.8	6.6
Эрдэс бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь	71.4	83.2	83.6	87.2	88.9	-	2.7
2. Эрдэсээс бусад бүтээгдэхүүний экспорт	807.6	685.0	872.2	969.1	872.2	-96.8	-10.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүнд нүүрс, зэсийн баяжмал, алт, төмрийн хүдэр, түүхий газрын тос, жоншны баяжмал, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн хамаарч байна.

Нийт экспортын орлогын 59.9 хувийг нүүрс, 18.4 хувийг зэсийн баяжмал, 4.4 хувийг алт, 3.7 хувийг төмрийн хүдэр, 2.1 хувийг боловсруулаагүй нефть, 1.7 хувийг жоншны баяжмал тус тус эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад газрын түүхий тос, цайрын баяжмал болон молибдены баяжмалаас бусад эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого өссөн байна.

Хүснэгт 14. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Гол нэр төрлийн бараа	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нүүрс (сая.т)	8.7	9.6	8.1	29.5	40.6	11.0	37.6
Зэсийн баяжмал(мян.т)	675.9	614.9	747.8	764.3	785.2	20.9	2.7
Алт (тн)	11.0	3.7	8.6	5.4	5.1	-0.3	-5.6
Төмрийн хүдэр (сая.т)	4.1	4.0	1.8	2.7	3.6	0.9	33.3
Боловсруулаагүй нефть (сая.барр)	0.9	2.8	0.1	2.4	2.1	-0.3	-12.5
Жоншны баяжмал (мян.т)	313.7	391.0	167.4	436.4	583.8	147.4	33.8
Цайрын баяжмал (мян.т)	66.6	66.7	73.4	100.1	62.1	-38.0	-38.0
Молибдены баяжмал (мян.т)	3.1	3.4	2.8	3.4	3.2	-0.2	-5.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/


Гол нэр төрлийн бараа	Экспортод эзлэх хувь	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт	
		2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нүүрс	59.9	690.8	1,026.9	2,349.7	4,393.7	4,725.3	331.6	7.5
Зэсийн баяжмал	18.4	741.1	1,312.9	1,590.7	1,329.8	1,454.4	124.6	9.4
Алт	4.5	606.4	218.0	514.1	337.6	356.0	18.4	5.5
Төмрийн хүдэр	3.7	283.2	550.8	173.9	229.2	292.5	63.3	27.6
Боловсруулаагүй нефть	2.1	34.0	168.4	12.3	176.3	165.8	-10.5	-6.0
Жоншны баяжмал	1.7	75.7	84.5	46.9	110.3	130.3	20.0	18.1
Цайрын баяжмал	1.1	80.1	101.1	155.2	164.2	85.4	-78.8	-48.0
Молибдены баяжмал	0.6	21.2	27.9	40.3	71.7	48.7	-23.0	-32.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Зэсийн баяжмал: 2024 оны эхний хагас жилд 785.2 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, экспортын орлого 1,454.4 сая ам.доллар болж, экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 124.6 сая ам.доллар буюу 9.4 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын экспортын тоо хэмжээ 20.9 мянган тонн буюу 2.7 хувиар, зэсийн баяжмалын хилийн үнэ 6.5 хувиар тус тус өссөн нь экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.


График 12. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төмрийн хүдэр: 2024 оны эхний хагас жилийн байдлаар 3.6 сая.тонн төмрийн хүдэр экспортолж, 292.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс төмрийн хүдрийн экспортын орлого 27.6 хувь буюу 63.3 сая ам.доллаароор өссөн. Үүнд төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 0.9 сая тонн буюу 34.1 хувиар өссөн нь нөлөөлжээ. Экспортын дундаж үнэ 81.3 ам.доллар болж өнгөрсөн оноос 4.9 хувиар буурчээ.

График 13. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Алт: 2024 оны эхний хагас жилд 5.1 тонн алт экспортолж, экспортын орлого 356.0 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 18.4 сая ам.доллар буюу 5.5 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс алтны үнэ 11.7 хувиар өссөн нь алтны экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Жоншны баяжмал: 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр жоншны баяжмалын экспортын тоо хэмжээ 583.8 мянган тонн-д хүрч, 130.3 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Жоншны баяжмалын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 33.9 хувь буюу 147.7 мянган тонноор өссөн нь жоншны экспортын орлого өсөхөд голлон нөлөөлжээ.

Нүүрс: 2024 оны эхний хагас жилийн байдлаар 40.6 сая тонн нүүрс экспортолж, 4.7 тэрбум ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспортын биет хэмжээ 11.1 сая тонн буюу 37.6 хувиар өссөн байна. Доорх графикаас харахад нүүрсний экспортын орлого нэмэгдэхэд нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн нь голлон нөлөөлжээ. 2024 оны эхний 3 сард дундажаар сард 6.0 сая тонн нүүрс экспортолж байсан нь өмнөх онуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

График 14. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Боловсруулаагүй нефть: 2024 оны эхний хагас жилд 2.1 сая баррель боловсруулаагүй нефть экспортолж, 165.8 сая ам.долларын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспортын орлого 10.4 сая ам.доллар буюу 5.9 хувиар буурсан байна. Үүнд боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ 0.3 сая баррелиар буурсан нь голлон нөлөөлсөн.

Цайрын баяжмал: 2024 оны эхний хагас жилд цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 62.1 мянган тонн болж, 85.4 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цайрын баяжмалын биет хэмжээ 38.0 хувь буюу 38.0 мянган тонноор, мөн үнэ дундажаар 16.1 хувиар тус тус буурсан нь цайрын баяжмалын экспортын орлого 78.8 сая ам.доллар буюу 48.0 хувиар буурахад нөлөөлжээ.

4.3. Импорт:

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр импортын худалдаа 5,377.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.8 хувь буюу 1,104.5 сая ам.доллараар өссөн байна.

График 15. Импорт, бүлгээр



2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт импортын 22.3 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 77.7 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,201.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 192.2 сая ам.доллар буюу 19.1 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 4,176.8 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 912.3 сая ам.доллар буюу 27.9 хувиар өсжээ.

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 18. Импорт, бүлгээр /2019-2023 он/он/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт импорт	2,460.1	3,261.5	3,948.0	4,273.4	5,377.9	1,104.5	25.8
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний импорт	485.3	551.6	877.5	1,008.9	1,201.1	192.2	19.1
Эрдэс бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь	19.7	16.9	22.2	23.6	22.3	-	-
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	1,974.8	2,709.9	3,070.5	3,264.5	4,176.8	912.3	27.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт импортын 28.3 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 43.2 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 8.7 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 19.7 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Хүснэгт 19. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


Бүтээгдэхүүн	Эхний хагас жилийн байдлаар						Өөрчлөлт (сая ам.дол)
	2022		2023		2024		
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	2024.06/ 2023.06
Хэрэглээ	1,308.0	33.1	1,245.0	29.1	1,522.0	28.3	277.0
- Түргэн эдэлгээтэй	725.0	18.4	621.0	14.5	708.0	13.2	87.0
- Удаан эдэлгээтэй	583.0	14.8	623.0	14.6	814.0	15.1	191.0
Хөрөнгө оруулалт	1,420.0	36.0	1,744.0	40.8	2,322.0	43.2	578.0
- Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	767.0	19.4	1,123.0	26.3	1,510.0	28.1	387.0
- Барилгын материал	496.0	12.6	481.0	11.3	584.0	10.9	103.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	157.0	4.0	141.0	3.3	228.0	4.2	87.0
Аж үйлдвэрлэлийн орц	442.0	11.2	398.0	9.3	466.0	8.7	68.0
Нефтийн бүтээгдэхүүн	766.0	19.4	880.0	20.6	1,060.0	19.7	180.0
- Дизель	394.0	10.0	523.0	12.2	649.0	12.1	126.0
- АИ-92, 95	260.0	6.6	244.0	5.7	308.0	5.7	64.0
- А80 ба бусад	112.0	2.8	114.0	2.7	103.0	1.9	-11.0
Бусад	12.0	0.3	6.0	0.1	9.0	0.2	3.0
Нийт дүн	3,948.0	100.0	4,273.4	100.0	5,378.0	100.0	1,104.5

Эх сурвалж: Монголбанк

2023 оны эхний хагас жилтэй харьцуулахад 2024 оны мөн үед импортын худалдаа 1,104.5 сая ам.доллаар нэмэгдэхэд хөрөнгө оруулалт 578.0 сая ам.доллар, хэрэглээ 277.0 сая ам.доллар, нефтийн бүтээгдэхүүн 180.0 сая ам.доллар, аж үйлдвэрийн орц 68.0 сая ам.доллаар тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүний дотор машин, механик тоног төхөөрөмж, эд анги 387.0 сая ам.доллар, дизель түлш 126.0 сая ам.доллар, барилгын материал 103.0 сая ам. доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 191.0 сая ам.доллаар тус тус нэмэгдсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оны мөн үеэс 180.0 сая ам.доллаар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ 1.9 хувиар өссөн нөлөөлжээ. Дизель түлшний импорт 126.0 сая ам.доллаар нэмэгджээ. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 115.3 ам.дол/баррель болж, 2023 оны жилийн эцсээс 3.7 хувиар өссөн байна.

График 16. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТАВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

5.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 41,467.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 10,019.1 тэрбум төгрөг буюу 31.9 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 3,308.2 тэрбум төгрөг буюу 44.3 хувиар, төгрөгийн хадгаламж 5,252.5 тэрбум төгрөг буюу 36.5 хувиар, гадаад валютын харилцах 1,835.8 тэрбум төгрөг буюу 51.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 20. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
				2024.06/2023.06	
	2022	2023	2024	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	27,635.5	31,448.2	41,467.3	10,019.1	31.9
Мөнгө M1	6,067.1	8,282.0	11,807.4	3,525.4	42.6
Төгрөгийн харилцах	5,309.8	7,459.6	10,767.8	3,308.2	44.3
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	757.3	822.4	1,039.6	217.2	26.4
Бараг мөнгө	21,568.4	23,166.2	29,659.9	6,493.7	28.0
Төгрөгийн хадгаламж	13,809.6	14,378.6	19,631.1	5,252.5	36.5
Валютын хадгаламж	4,526.4	5,195.9	4,601.3	- 594.6	-11.4
Валютын харилцах	3,232.4	3,591.7	5,427.5	1,835.8	51.1
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	1,034.9	1,098.5	1,338.2	239.7	21.8

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 33.5 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 7.9 их наяд төгрөг буюу 30.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 21. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
				2024.06/2023.06	
	2022	2023	2024	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	23,471.3	25,575.5	33,486.5	7,910.9	30.9
-Хэвийн зээл	20,265.3	22,036.1	30,294.0	8,257.9	37.5
-Хугацаа хэтэрсэн зээл	1,104.2	1,325.4	1,235.3	-90.1	-6.8
-Чанаргүй зээл	2,101.8	2,214.1	1,957.2	-256.8	-11.6
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	4.7	5.2	3.7	-	-
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	9.0	8.7	5.8	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 58.8 хувь нь иргэдийнх, 39.4 хувь нь хувийн хэвшлийн байгууллагынх эзэлж байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 30,294.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8,257.9 тэрбум төгрөг буюу 37.5 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 90.4 хувийг хэвийн зээл, 5.8 хувийг чанаргүй зээл, 3.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл 1,235.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 90.1 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.7 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурлаа.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 1,957.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 256.8 тэрбум төгрөг буюу 11.6 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 2.9 нэгж хувиар буурчээ.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2024 оны 6 дугаар сарын байдлаар 797.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 785.3 сая ширхэг үнэт цаас арилжаалжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнэт цаасны арилжааны гүйлгээ 284.2 тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас 76.3 сая ширхгээр тус тус нэмэгдсэн байна. 2024 оны 6 дугаар сард хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны нийт үнэлгээний дүн 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 347.0 тэрбум төгрөг буюу 3.2 хувиар өссөн байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2024 оны 6 дугаар сард 43,080.3 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 6,604.3 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 оны 06 дугаар сард 3,381.0 төгрөг болж, өмнөх оноос 57.0 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 466.0 төгрөг болж, өмнөх оноос 14.0 төгрөгөөр мөн чангарсан байна.

График 17. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн хани, /2024.06 байдлаар/ /төгрөгөөр/




Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 5.1 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар буурсан байна.

Нэмж дурдахад, 2020-2022 онд тээвэр логистикийн хүндрэл, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэйгээр хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөн нь дэлхийн улс орнуудад инфляц өндөр байхад голлон нөлөөлсөн. Монгол Улсын хувьд мөн шалтгааны улмаас удаан хугацаанд буюу 25 сарын туршид инфляц 10-аас дээш хувьтай байснаа 2023 оны 9 дүгээр сараас хойш 10-аас доош түвшин рүү орсон байна.

График 18. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт, хувиар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2024 оны 6 сард 4,838.8 сая ам.доллар болж, 2023 оны жилийн эцсээс 82.7 сая ам.доллар буюу 1.7 хувиар буурсан хэдий ч өнгөрсөн оны мөн үеэс 1,021.0 сая ам.доллар буюу 26.7 хувиар өссөн байна.

График 19. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллороор/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2024 оны 6 дугаар сард 4,838.8 сая ам.доллар болж нийт импортын 5.4 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 22. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	Эхний хагас жилийн гүйцэтгэл				
		2020	2021	2022	2023	2024
1	Нийт импорт	2,460.1	3,261.5	3,948.0	4,273.4	5,377.9
2	Гадаад валютын нийт нөөц	3,555.9	4,731.8	3,097.2	3,817.8	4,838.8
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	8.6	8.7	4.7	5.4	5.4

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Худалдан авсан алт: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 7.8 тонн болж, 2023 оны мөн үеэс 0.5 тонноор өссөн байна. Сүүлийн 5 жилийн хугацаагаар нь авч үзэхэд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ эхний 6 сарын байдлаар 7.3-10.8 тонн байсан. Үүний дотор 2020 онд буюу Ковидын үед хамгийн өндөр худалдан авалтыг хийсэн байна.

График 20. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2013.06-2024.06 гүйцэтгэл /тонн/



Эх сурвалж: Монголбанк

5.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 804.6 сая ам.долларын алдагдалтай байсан хэдий ч хөрөнгийн тэнцэл 18.5 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 602.0 сая ам.долларын тус тус ашигтай гарсан.

Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан хэдий ч худалдааны тэнцэл алдагдалтай байсан учраас төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 57.3 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 531.0 сая ам.доллаар суларсан байна.

2024 оны эхний хагас байдлаар урсгал тэнцэл алдагдалтай гарахад бараа, үйлчилгээний худалдааны тэнцэл 584.2 сая ам.доллар, мөн анхдагч орлого 294.2 сая ам.долларын алдагдалтай байсан нь голлон нөлөөлсөн.


Хүснэгт 23. Төлбөрийн тэнцэл, 2022-2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний хагас жилийн гүйцэтгэл			Өөрчлөлт
	2022	2023	2024	Дүн
I. Урсгал Тэнцэл	-1,360.8	221.2	-583.4	-804.6
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-988.4	1,066.5	482.3	-584.2
В. Анхдагч орлого	-573.9	-1,024.4	-1,318.6	-294.2
С. Хоёрдогч орлого	201.5	179.0	253.0	74.0
II. Хөрөнгийн тэнцэл	54.6	59.9	78.4	18.5
III. Санхүүгийн тэнцэл	-925.8	-58.3	-660.3	-602.0
IV. Алдаа болон орхигдуулга	-677.5	134.4	-212.6	-347.0
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-1,058.0	473.7	-57.3	-531.0

Эх сурвалж: Монголбанк

График 21. Төлбөрийн тэнцэл, 2009-2024 он



Эх сурвалж: Монголбанк

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙДАЛ

6.1. Хүн ам, ажил эрхлэлт


2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр улсын хэмжээнд 28.8 мянган хүүхэд шинээр төрсөн байна. 2024 оны эхний 6 сарын байдлаар нийт ажиллах хүчний тоо 1,429.4 мянга болж, 2023 оны жилийн эцсээс 53.8 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс 1,347.1 мянган хүн нь ажилтай, 82.3 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилтай иргэдийн тоо 38.6 мянгаар нэмэгдэж, ажилгүй хүмүүсийн тоо 6.1 мянгаар буурсан байна.

2024 оны 2 дугаар улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар өссөн байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 70.5 хувь, эмэгтэйчүүдийнх 54.5 хувь байна. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.6 хувь байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 868.5 мянга байна.

6.2. Ажилгүйдлийн түвшин

2024 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 5.8 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.7 нэгж хувиар тус тус өссөн байна.

График 18. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС